

**МОНГОЛ УЛСЫН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2015  
ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ  
ХИЙСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 11 дүгээр  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн С.Одонтуяа**

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хийж, дараах санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанд хуулийн төслүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, А.Бакей, Д.Арвин, Л.Эрдэнэчимэг, З.Баянсэлэнгэ нар Сангийн яамны Ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсаны дараа Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгээс гаргасан горимын саналын дагуу дээрх хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг түр хойшлуулж, Байнгын хорооны хуралдаанаас Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн саналаар төслүүдийн талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Арвинаар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, С.Одонтуяа, А.Бакей, З.Баянсэлэнгэ, С.Ганбаатар, А.Тлейхан нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулав.

Ажлын хэсэг “Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад дурдсан аймаг, нийслэлд хэрэгжүүлэх нийгмийн зорилтот хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг холбогдох сайдын багцад нь бүрэн суулгах /хавсралт 1/,” “Өмнөх онуудад ажил нь эхлээд 2015 оны төсөвт суулгаагүй байгаа нийгмийн салбарын хөрөнгө оруулалтыг 2015 оны төсөвт холбогдох сайдын багцад нэмж тусгах /хавсралт 2/” саналын томьёолол тус тус бэлтгэснийг Байнгын хорооны хуралдаанаар санал хураалт явуулахад, хуралдаанд оролцсон 11 гишүүн 100 хувийн саналаар дэмжлээ.

Ажлын хэсгээс “Ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байр, биеийн тамирын заал, эмнэлгийн барилга хангамжийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх мөн дэмжив.


Тэрчлэн Байнгын хорооны гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудаар нэгбүрчлэн санал хураалт явуулж, саналын томьёоллуудыг Байнгын хорооны санал, дүгнэлтэд хавсаргасан болно.

Төсвийн байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА



Д.БАТЦОГТ

БААГДАА ОХИДАА НАМТДАА НИИСТРИЛЧУ НИУС ДААГ  
НЭОУСТАРХАА НАМТДАА НИИСТРИЛЧУ НИУС ДААГ  
ЖСОНЫД ЖАСОГД НАМТДАА НИИСТРИЛЧУ НИУС ДААГ  
НЭСҮҮЛНААТ